# БАЯНХОНГОР АЙМАГ
# БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 30 өдөр Дугаар А/62 Хөхбүрд

Газар эзэмших эрхийн гэрчилгээт
дуудлага худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 5.1.2, Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар "Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 2024 оны 03/07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг зарласугай.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдаа явуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, дуудлага худалдааны анхны үнийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр журмын дагуу зохион байгуулж ажиллахыг дуудлага худалдаа зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд даалгасугай.

4.Дуудлага худалдаа явуулах зарыг mle.mn сайтад байршуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад нээлттэй хүргэж, мэдээллээр хангаж ажиллахыг Газрын даамал (Э.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА Т.БЯМБАДОРЖ

64250106?

Засаг даргын 2025 оны 05 дугаар
сарын 30 -ны өдрийн А/62 дугаар
захирамжийн хавсралт

## ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын мэдээлэл | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Талбайн хэмжээ /$м^2$/ | Байршил | Зориулалт | Эрхийн төрөл | Дуудлага худалдааны анхны үнэ /төг/ | Дэнчин /төг/ | Дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр | Тайлбар |
| 1 | 4377507 | 6012 | Мэргэн 4-р баг, Улаан-Эрэг | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | Эзэмших | 4 809 600 | 480 960 | 2025.06.30 | Цахим хэлбэрээр зохион байгуулна |
| 2 | 4369606 | 400 | Мандалхайрхан 1-р баг | Холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц | | 320 000 | 32 000 | | |
| 3 | 4313714 | 306563 | Мандалхайрхан 1-р баг | Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам | | 245 250 400 | 24 525 040 | | |

___________o0o___________